

БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙЧД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ, ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү шалгуур үзүүлэлт нь Биеийн тамирын арга зүйчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ур чадварыг тодорхойлох, үнэлэх, дэмжин урамшуулахад чиглэгдэнэ.

1.2.Биеийн тамирын арга зүйч нь мэргэшлийн зэрэг нь I, II, III гэсэн 3 шатлалтай байна.

1.3.Биеийн тамир, спортын мэргэшлийн боловсрол олгох их, дээд сургуулийг биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйчийн мэргэжлийн бакалаврын боловсролтой төгссөн, биеийн тамирын арга зүйчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид мэргэшлийн зэрэг олгоно.

1.4.Биеийн тамирын арга зүйчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 6-д заасны дагуу зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд, тус журмын 2-т зааснаар мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоно.

1.5. Биеийн тамирын арга зүйчийн мэргэшлийн зэргийг сумдын биеийн тамирын арга зүйч, аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын биеийн тамирын асуудал эрхэлсэн нэгжийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, даргаар ажиллаж буй албан хаагчид болон бусад төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдэд биеийн тамирын арга зүйчээр үндсэн орон тоонд ажиллаж буй албан хаагчдад олгоно.

1.6. Төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагад биеийн тамирын арга зүйчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох ба мэргэшлийн зэргийн нэмэгдлийг жишиглэж тухайн байгууллага олгож болно.

1.7. Биеийн тамирын арга зүйчийн мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон баримт бичгийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээллийн цахим санд байршуулж, архивын нэгж болгон хадгална.

Хоёр.Мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлт

2.1. Ерөнхий шаардлага

2.1.1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсрол олгох их, дээд сургуулийг биеийн тамир багш, дасгалжуулагч, арга зүйчийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн байх.

2.1.2. Арга зүйчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид мэргэшлийн зэрэг олгохдоо I зэргийг 9 ба түүнээс дээш жил, II зэргийг 6 ба түүнээс дээш жил, III зэргийг 3 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.

2.1.3. Арга зүйчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулсан төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдаж хангалттай үнэлгээтэй дүүргэсэн байх.

2.2. Мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэл

2.2.1. Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Итгэлцүүр	Мэдээллийн эх сурвалж	Тооцох аргачлал	Үнэлгээ	
1	Үйл ажиллагааны чанар	30 оноо	Бие бялдрын түвшин тогтоох сорилын D, F үнэлгээтэй хүн амын өөрчлөлтийн хувь	Сорилын цахим системийн мэдээлэл (линз оруулах)	Тухайн зэрэг горилогчид хамаарах нутаг дэвсгэрийн сорилын мэдээллээс D, F үнэлгээтэй хүн амын хувийг нийт хүн амаас жилээр тооцож, сүүлийн 3 жилийн өөрчлөлтийг гаргана.	D, F үнэлгээ буурсан	30 оноо
						D, F үнэлгээ өөрчлөгдөөгүй	10 оноо
						D, F үнэлгээ өссөн	0 оноо
2	Мэргэжил, ур чадвар;	30 оноо	Тухайн нутаг дэвсгэрт байрлах хүн амын идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадлын өөрчлөлтийн хувь	Сорилын цахим системийн мэдээлэл (линз оруулах)	Тухайн зэрэг горилогчид хамаарах нутаг дэвсгэрийн сорилын мэдээллээс мэдлэг, хандлага, дадлын хангалттай үнэлгээтэй хүн амын хувийг нийт хүн амаас тооцож, сүүлийн 3 жилийн өөрчлөлтийг гаргана.	Мэдлэгийн хувь өссөн	10 оноо
						Мэдлэгийн хувь өөрчлөгдөөгүй	5 оноо
						Мэдлэгийн хувь буурсан	0 оноо
						Хандлагын хувь өссөн	10 оноо
						Хандлагын хувь өөрчлөгдөөгүй	5 оноо
						Хандлагын хувь буурсан	0 оноо
						Дадлын хувь өссөн	10 оноо
						Дадлын хувь өөрчлөгдөөгүй	5 оноо
Дадлын хувь буурсан	0 оноо						
3	Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамж	20 оноо	1. Үйлчлүүлэгч, суралцагч, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч, хамт олноос гомдол гараагүй байх	Байгууллагын бичиг хэргийн системийн мэдээлэл	Тухайн зэрэг горилогчид хамаарах байгууллагын бичиг хэргийн мэдээллээс сүүлийн 3 жилийн бүртгэгдсэн мэдээллээс гаргана.	Гомдол гараагүй	10 оноо
						Гомдол гарсан	0 оноо
			2. Ажлын байранд эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хангаж, осол гэмтэл, зөрчил гаргаагүй байх	Байгууллагын архив	Тухайн зэрэг горилогчид хамаарах байгууллагын бичиг хэргийн мэдээллээс сүүлийн 3 жилийн бүртгэгдсэн мэдээллээс гаргана.	Зөрчил гаргаагүй	10 оноо
						зөрчил гарсан	0 оноо
4	Өөрийгөө хөгжүүлсэн байдал	10 оноо	Мэргэжилийн байгууллагаас зохион байгуулсан	Богино хугацааны мэргэжлийн чиглэлээр	Богино хугацааны мэргэжлийн чиглэлээр сургалтад сүүлийн 3 жилийн	Сургалтад хамрагдсан	10 оноо

			сургалтад хамрагдсан байдал	сургалтад суусан гэрчилгээ, батламжийн хуулбар	хугацаанд 2 хамрагдсан	Сургалтад хамрагдаагүй	0 оноо
5	Судалгаа шинжилгээ, шинэ бүтээл, инновац нэвтрүүлсэн ажил	10 оноо	Эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн хуралд өөрөө болон хамтран хэлэлцүүлсэн байх	Эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн хуралд оролцсон батламж	Сүүлийн 3 жилд эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн хуралд өөрөө болон хамтран хэлэлцүүлсэн байх	Хэлэлцүүлсэн	10 оноо
						Хэлэлцүүлээгүй	0 оноо
Нийт		100 оноо					

2.2.2. Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлгээгээр 70 болон 70-аас дээш оноогоор үнэлэгдсэн арга зүйчд мэргэшлийн зэрэг олгоно.

2.2.3. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 2.2.1-т үнэлгээг аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар албан хаагчдын хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд байгууллагын даргын албан бичгээр баталгаажуулан ирүүлнэ.

2.3. Биеийн тамирын арга зүйч нь 2.1-т заасан ерөнхий шаардлагыг хангасан тохиолдолд аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар 2.2-т заасны дагуу сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг тооцож, арга зүйчд мэргэшлийн зэрэг олгох хүсэлт болон холбогдох баримтыг Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

Гурав. Мэргэшлийн зэрэг гориллох хүсэлт гаргах, зэрэг олгох

3.1. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 1.5, 1.6-д заасан мэргэшлийн зэрэг гориллогчийн дараах баримт бичгийг бүрдүүлж, харьяалах орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагаар дамжуулан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.1.1. Мэргэшлийн зэрэг горилж буй хүсэлт /өргөдөл/;

3.1.2. Төрийн албан хаагчийн анкет;

3.1.3. Мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар;

3.1.4. Ажилд орсон тушаалын хуулбар,

3.1.5. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 2.1.2-т заасан тасралтгүй ажилласныг тодорхойлох нийгмийн даатгалын хуулбар;

3.1.4. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдсан гэрчилгээний баталгаажсан хуулбар;

3.1.5. Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хангасан гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудас;

3.2. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 3.1-д заасан баримт бичгийг тухайн аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын даргаар уламжлуулан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын www.sport.gov.mn цахим хуудсаар цахим хэлбэрээр илгээнэ.

3.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Биеийн тамирын асуудал хариуцсан бүтцийн нэгж нь энэхүү шалгуур үзүүлэлтийн 3.2-т заасан мэргэшлийн зэрэг горилогчийн илгээсэн баримт бичгийг нягтлан судалж, мэргэшлийн зэрэг олгох болон шаардлага хангаагүй арга зүйчдийн мэдээллийг нэгтгэн, дүгнэлт боловсруулж, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд уламжилна.

3.4. Энэхүү журмын 3.3-т заасан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн зэргийн шаардлага хангасан биеийн тамирын арга зүйчд Биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр мэргэшлийн зэргийг олгоно.

3.5. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангаагүй тохиолдолд үндэслэл бүхий тайлбар, зөвлөмжийг албан бичгээр эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

Дөрөв. Мэргэшлийн зэрэг олгох, хүчинтэй хугацаа

- 1.1. Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жилийн хугацаагаар олгоно.
- 1.2. Мэргэшлийн I зэргийг хугацаагүй олгоно.
- 1.3. Мэргэшлийн зэргийг шатлал алгасан олгохгүй.

Тав. Мэргэшлийн зэргийг хэвээр хадгалах, хүчингүй болгох

5.1. дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хэвээр хадгална:

5.1.1. Хөдөлмөрийн тухайн хуулийн 106.1-д заасны дагуу жирэмсний болон амаржсаны, хүүхэд харах чөлөөтэй байх 3 түртэл жил

5.1.2. ажил олгогчийн чөлөөгөөр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын түвшний сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 түртэл жил

5.1.3. цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 жил

5.1.4. өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдлын улмаас ажил олгогчоос чөлөө авсан тохиолдолд 1 жил хүртэл

5.1.5. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 2 түртэл жил өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн орон тоонд ажиллаж эхэлсэн хугацаанаас эхлэн үргэлжлүүлэн тооцно.

5.2. Мэргэшлийн зэргийг дараах тохиолдлыг үндэслэн мэргэшлийн зэрэг олгосон албан тушаалтан нь хүчингүй болгоно:

5.2.1. Мэргэшлийн зэргийн хугацаа дууссан.

5.2.2. Мэргэшлийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 3 жилээс дээш хугацаагаар ажиллаагүй тохиолдолд зэргийг хүчингүйд тооцно.

5.2.3. төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь ёс

зүйн хорооны дүгнэлтээр тогтоогдсон

Зургаа .Мэргэшлийн зэргийн үнэмлэхийн загвар

6.1.Мэргэшлийн зэргийн үнэмлэх нь доорх загвартай байна.

6.1.1. А4 цаасны 4/1 дээр хийх бөгөөд дотор талын зүүн талын дээд өнцөгт цээж зураг, үнэмлэхийн дугаар байна. Дугаарын доод талд овог нэр, сургууль, аймаг, нийслэлийн комиссын шийдвэр, зэрэг олгосон хүний албан тушаал, гарын үсэг байна. Түүний доор олгосон он, сар, өдрийг бичнэ. Хуудасны баруун талд хугацааг сунгасан шийдвэр, он, сар, өдөр, олгосон хүний гарын үсэг, албан тушаалыг бичнэ. Үнэмлэх нь хавтастай байх бөгөөд "МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ" гэсэн бичиглэлтэй байна.

---o0o---

СПОРТЫН ДАСГАЛЖУУЛАГЧД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ, ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Спортын дасгалжуулагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ур чадварыг тодорхойлох, үнэлэх, дэмжин урамшуулахад чиглэгдэнэ.

1.2.Спортын дасгалжуулагч нь мэргэшлийн I, II, III гэсэн 3 шатлалтай байна.

1.3.Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсрол олгох их, дээд сургуулийг биеийн тамир багш, дасгалжуулагч мэргэжлийн бакалаврын боловсролтой төгссөн, спортын дасгалжуулагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид мэргэшлийн зэрэг олгоно.

1.4.Спортын дасгалжуулагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 6-д заасны дагуу зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд, тус журмын 2-т зааснаар мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоно.

1.5.Спортын дасгалжуулагчийн мэргэшлийн зэргийг аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын спортын асуудал эрхэлсэн нэгжийн дасгалжуулагч, ахлах дасгалжуулагч, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, даргын албан тушаалд ажиллаж буй албан хаагчид болон бусад төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдэд спортын дасгалжуулагч, ахлах дасгалжуулагчаар ажиллаж буй албан хаагчид олгоно.

1.6.Төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагад спортын дасгалжуулагч, ахлах дасгалжуулагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох ба мэргэшлийн зэргийн нэмэгдлийг жишиглэж тухайн байгууллага олгож болно.

1.7.Спортын дасгалжуулагчийн мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон баримт бичгийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээллийн цахим санд байршуулж, архивын нэгж болгон хадгална.

Хоёр.Мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур

2.1. Ерөнхий шалгуур

2.1.1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсрол олгох их, дээд сургуулийг биеийн тамир багш, дасгалжуулагч мэргэжлийн бакалаврын боловсролтой төгссөн байх.

2.1.2.Спортын дасгалжуулагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагчид I

зэргийг 9 ба түүнээс дээш жил, II зэргийг 6 ба түнээс дээш жил, III зэргийг 3 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.

2.1.3. Спортын дасгалжуулагч нь биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулсан төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдаж хангалттай үнэлгээтэй төгссөн байх.

2.2. Мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэл

2.2.1. Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт		Үнэлгээ	Итгэлцүүр	Мэдээллийн эх сурвалж	Тооцох аргачлал		Үнэлгээ
1.		Дасгалжуулалтын чанар	30 оноо	Тамирчин нь биеийн ерөнхий хөгжил, тусгай хөгжил, биологийн хөгжил зохих насны дундаж үзүүлэлтийг хангасан байх.	Мэдээллийн санд бүртгэлтэй тамирчдын үзүүлэлт	Тамирчны сүүлийн 3 жилийн үзүүлэлтийг ахицаар тооцон	Ахиц гарсан	30 оноо
							Ахиц гараагүй	0 оноо
2.		Мэргэжлийн ур чадвар	30 оноо	Хичээллэж буй тамирчдын амжилт	Мэдээллийн санд бүртгэлтэй тамирчдын үзүүлэлт	Тухайн зэрэг горилогчид хамаарах баг тамирчдын сүүлийн 3 жилийн улсын аварга шалгаруулах тэмцээн, улсын хэмжээн наадам гаргасан амжилтын ахицаар тооцон	Ахиц гарсан	30 оноо
							Ахиц гараагүй	0 оноо
3.	Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт	Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамж	20 оноо	1. Мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой гомдол тамирчид, сонирхон хичээллэгч, эцэг эх, асран хамгаалагч, хамт олноос гараагүй байх	Байгууллагын бичиг хэргийн системийн мэдээлэл	Тухайн зэрэг горилогчид хамаарах байгууллагын бичиг хэргийн мэдээллээс сүүлийн 3 жилийн бүртгэгдсэн мэдээллээс гаргана.	Гомдол гараагүй	10 оноо
							Гомдол гарсан	0 оноо
				2. Ажлын байранд эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, осол гэмтэл, зөрчил гаргаагүй байх	Байгууллагын архив		Зөрчил гаргаагүй	10 оноо
							Зөрчил гарсан	0 оноо
4.			10 оноо	Мэргэжилийн байгууллагаас	Богино хугацааны	Богино хугацааны	Сургалтад хамрагдсан	10 оноо

		Өөрийгөө хөгжүүлсэн байдал		зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал	дасгалжуулалтын чиглэлийн сургалтад суусан гэрчилгээ, батламжийн хуулбар	дасгалжуулалтын чиглэлийн сургалтад сүүлийн 3 жилийн хугацаанд 2 хамрагдсан	Сургалтад хамрагдаагүй	0 оноо
5.		Судалгаа дүгнэлт хийж, шинэ арга зүй нэвтрүүлсэн эсэх	10 оноо	1.Сургалт дасгалжуулалтын чиглэлээр судалгаа хийж эрдэм шинжилгээ, онол, практикийн хуралд өөрөө болон хамтран хэлэлцүүлсэн байх	Эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн хуралд оролцсон батламж	2 удаа онол, практикийн хуралд оролцсон байх	2 удаа оролцсон	10 оноо
							1 удаа оролцсон	5 оноо
							0 удаа оролцсон	0 оноо
Нийт оноо			100 оноо					

2.2.2.Сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлгээгээр 70 болон 70-аас дээш оноогоор үнэлэгдсэн арга зүйчд мэргэшлийн зэрэг олгоно.

2.2.3.Энэхүү шалгуур үзүүлэлтийн 2.2.1-т үнэлгээг аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар албан хаагчдын хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд байгууллагын даргын албан бичгээр баталгаажуулан ирүүлнэ.

2.3.Спортын дасгалжуулагч нь 2.1- т заасан ерөнхий шаардлагыг хангасан тохиолдолд аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар 2.2-т заасны дагуу сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийг тооцож, арга зүйчд мэргэшлийн зэрэг олгох хүсэлт болон холбогдох баримтыг Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

Гурав. Мэргэшлийн зэрэг горилох хүсэлт гаргах, олгох

3.1.Энэхүү шалгуур үзүүлэлтийн 1.5, 1.6-д заасан мэргэшлийн зэрэг горилогч нь дараах баримт бичгийг бүрдүүлж, харьяалах орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын албан бичгээр Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.1.1. Мэргэшлийн зэрэг горилж буй хүсэлт /өргөдөл/;

3.1.2. Төрийн албан хаагчийн анкет;

3.1.3. Мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар;

3.1.4. Ажилд орсон тушаалын хуулбар

3.1.3.Ажилд орсон тушаалын хуулбар, энэхүү шалгуур үзүүлэлтийн 2.2-т заасан тасралтгүй ажилласныг тодорхойлох нийгмийн даатгалын хуулбар;

3.1.4.Энэхүү шалгуур үзүүлэлт ийн 1.6-д заасан хангасан спортын холбооны тодорхойлолт;

3.1.5.Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан гэрчилгээний баталгаажсан хуулбар;

3.1.6. Энэхүү шалгуурын 2.1-т заасан сүүлийн 3 жилийн ажлын гүйцэтгэлийн

үнэлгээг хангасан гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас;

3.1.7. Тамирчидтай байгуулсан гэрээний хуулбар;

3.2. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 3.1-д заасан баримт бичгийг тухайн аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын даргаар уламжлуулан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын www.sport.gov.mn цахим хуудсаар цахим хэлбэрээр илгээнэ.

3.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Биеийн тамирын асуудал хариуцсан бүтцийн нэгж нь энэхүү шалгуур үзүүлэлтийн 3.2-т заасан мэргэшлийн зэрэг горилогчийн илгээсэн баримт бичгийг нягтлан судалж, мэргэшлийн зэрэг олгох болон шаардлага хангаагүй арга зүйчдийн мэдээллийг нэгтгэн, дүгнэлт боловсруулж, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд уламжилна.

3.4. Энэхүү журмын 3.3-т заасан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн зэргийн шаардлага хангасан биеийн тамирын арга зүйчд Биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр мэргэшлийн зэргийг олгоно.

3.5. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангаагүй тохиолдолд үндэслэл бүхий тайлбар, зөвлөмжийг албан бичгээр эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

Дөрөв. Мэргэшлийн зэрэг олгох, хүчинтэй хугацаа

4.1. Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жилийн хугацаагаар олгоно.

4.2. Мэргэшлийн I зэргийг хугацаагүй олгоно.

4.3. Мэргэшлийн зэргийг шатлал алгасан олгохгүй.

Тав. Мэргэшлийн зэргийг хэвээр хадгалах, хүчингүй болгох

5.1. дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хэвээр хадгална:

5.1.1. Хөдөлмөрийн тухайн хуулийн 106.1-д заасны дагуу жирэмсний болон амаржсаны, хүүхэд харах чөлөөтэй байх 3 түртэл жил

5.1.2. Ажил олгогчийн чөлөөгөөр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын түвшний сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 түртэл жил

5.1.3. Цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 жил

5.1.4. Өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдлын улмаас ажил олгогчоос чөлөө авсан тохиолдолд 1 жил хүртэл

5.1.5. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 2 түртэл жил өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн орон тоонд ажиллаж эхэлсэн хугацаанаас эхлэн үргэлжлүүлэн тооцно.

.2. Мэргэшлийн зэргийг дараах тохиолдлыг үндэслэн мэргэшлийн зэрэг олгосон албан тушаалтан нь хүчингүй болгоно:

5.2.1. Мэргэшлийн зэргийн хугацаа дууссан.

5.2.2. Мэргэшлийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 3 жилээс дээш хугацаагаар ажиллаагүй тохиолдолд зэргийг хүчингүйд тооцно.

5.2.3. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн хорооны дүгнэлтээр тогтоогдсон

Зургаа .Мэргэшлийн зэргийн үнэмлэхийн загвар

6.1.Мэргэшлийн зэргийн үнэмлэх нь доорх загвартай байна.

6.1.1. А4 цаасны 4/1 дээр хийх бөгөөд дотор талын зүүн талын дээд өнцөгт цээж зураг, үнэмлэхийн дугаар байна. Дугаарын доод талд овог нэр, сургууль, аймаг, нийслэлийн комиссын шийдвэр, зэрэг олгосон хүний албан тушаал, гарын үсэг байна. Түүний доор олгосон он, сар, өдрийг бичнэ. Хуудасны баруун талд хугацааг сунгасан шийдвэр, он, сар, өдөр, олгосон хүний гарын үсэг, албан тушаалыг бичнэ. Үнэмлэх нь хавтастай байх бөгөөд "МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ" гэсэн бичиглэлтэй байна.

---o0o---

Саналыг:

Soyolmaa@mocsty.gov.mn цахим хаяг

<https://forms.gle/6JE8kVxX3vgf4NRP7> линк-ээр ирүүлнэ үү.